



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

№ 2026-03-К3 № 629
танай _____-ны № _____-т

НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИЙН ПАРК ХК-ЫН ДАРГА
Ч.РАДНААБАЗАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Компани тайлант онд нийт 2,246.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаандаа 1,289.5 сая төгрөгийг зарцуулж, 957.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Орлого нэмэгдэж, ашиг өссөн нь үнэ төлбөргүй авсан хөрөнгийн орлого 1,108.5 сая төгрөг, бусад орлого 338.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь шууд нөлөөлсөн байна.

Аудитын гол асуудал

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 38 дугаар тогтоолоор Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК болгон дүрмийг баталсны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Улсын бүртгэлийн гэрчилгээнд 73.9 сая төгрөгийн дүрмийн сантай хаалттай хувьцаат компани, үйл ажиллагааны чиглэлийг Нийгэм эдийн засаг, байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөөлөлгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэ дэвшилтэд болон өндөр технологи дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулах бизнесийн тэвтэй орчныг бүрдүүлэх замаар төлөвлөгдсөн газрыг паркийн бус болгон хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	30,227,202.21	116,837,522.36
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	96,621,180.88
3121	Төгрөг	0.00	96,621,180.88
31213	Арилжааны банк дахь харилцах		96,621,180.88
33	АВЛАГА	9,279,119.21	0.00
335	Бусад авлага	9,279,119.21	0.00
3351	Байгууллагаас авах авлага	6,818,000.21	
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,461,119.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	20,948,083.00	20,216,341.48
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	13,000,000.00	13,000,000.00
354	Хангамжийн материал	7,948,083.00	7,216,341.48
35410	Бичиг хэргийн материал	943,090.00	443,490.00
35420	Аж ахуйн материал	6,637,550.00	6,388,600.00
35440	Түлш, шатах тослох материал	367,443.00	384,251.48
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	72,608,480,695.48	73,479,994,244.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	72,608,480,695.48	73,479,994,244.37
392	Биет хөрөнгө	9,222,864,862.50	10,093,243,911.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	725,673,378.00	725,673,378.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-152,257,596.26	-170,399,430.74
39203	Авто-тээврийн хэрэгсэл	68,380,000.00	38,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-68,380,000.00	-640,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,405,500.00	47,022,830.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-40,652,226.39	-11,922,835.55
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,774,100.00	51,642,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,132,833.58	-3,667,351.10
39209	Зам, гүүрийн байгууламж	8,679,010,383.99	9,693,359,114.99
39210	Хуримтлагдсан элэгдэл	-36,162,543.26	-276,383,294.54
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,276,790.00	1,276,790.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,070,090.00	-1,117,790.00
393	Биет бус хөрөнгө	63,385,615,832.98	63,386,750,333.31
39301	Програм хангамж	4,244,000.00	4,324,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,649,667.02	-2,595,166.69
39303	Бусад биет бус хөрөнгө	63,385,021,500.00	63,385,021,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	72,638,707,897.69	73,596,831,766.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	86,000.00	890,351.56
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	86,000.00	890,351.56
413	Өглөг	86,000.00	890,351.56
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	86,000.00	
4136	Бусад өглөг	0.00	890,351.56
41361	Байгууллагад төлөх өглөг		890,351.56
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	72,638,621,897.69	73,595,941,415.17
51	Засгийн газрын хувь оролцоо	72,638,621,897.69	73,595,941,415.17

Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	22,238,296,000.00	22,238,296,000.00
51101	Өмч: - төрийн	22,238,296,000.00	22,238,296,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	50,400,325,897.69	51,357,645,415.17
51210	Өмнөх үеийн үр дүн	50,400,325,897.69	50,400,325,897.69
51220	Тайлант үеийн үр дүн		957,319,517.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	72,638,707,897.69	73,596,831,766.73

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,183,584,520.74	2,246,834,607.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,679,010,383.99	2,246,834,607.61
120	Нийтлэг татварын бус орлого	8,679,010,383.99	2,246,834,607.61
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	8,679,010,383.99	1,108,292,731.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		262,003.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		1,138,279,873.10
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		282,839,597.10
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,228,000,000.00	855,440,276.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	501,346,136.75	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	558,617,149.70	1,289,515,090.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	558,617,149.70	1,289,515,090.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	555,389,149.70	1,288,515,090.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305,303,489.47	488,125,031.80
210101	Үндсэн цалин	174,197,644.47	393,387,811.80
210102	Нэмэгдэл	58,061,894.00	29,402,620.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,952,320.00	65,334,600.00
210104	Урамшуулал	19,091,631.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,150,600.00	59,859,642.00
210201	Тэтгэврийн даатгал	27,982,400.00	40,796,852.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,292,100.00	4,743,360.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,633,600.00	2,776,281.00
210204	Ажилгүйдлийн даатгал	658,400.00	1,965,075.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,584,100.00	9,578,074.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,368,266.73	292,116,751.00
210301	Гэрэл, цахилгаан	40,368,266.73	277,392,251.00
210303	Цэвэр, бохир ус	9,000,000.00	14,724,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,063,052.02	67,069,554.03
210401	Бичиг хэрэг	2,810,901.20	9,335,730.00
210402	Тээвэр, шатахуун	11,312,557.00	10,400,995.03
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,150,743.82	4,291,419.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,630,000.00	1,045,000.00

Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,158,850.00	
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		41,996,410.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,972,350.00	47,929,000.00
210604	Урсгал засвар	14,972,350.00	47,929,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,314,500.00	55,625,879.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,245,800.00	54,119,741.22
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	143,100.00	789,634.76
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,000.00	452,704.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	615,800.00	0.00
210807	Газрын төлбөр	208,800.00	208,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,216,891.48	277,789,231.32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,200,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,216,891.48	267,310,112.11
210904	Найдваргүй авлагын алдагдал		9,279,119.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,228,000.00	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,228,000.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,228,000.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8,624,967,371.04	957,319,517.48
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,624,967,371.04	957,319,517.48

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	504,574,136.75	1,138,279,873.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	1,138,279,873.10
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	1,138,279,873.10
120017	Татаас, санхүүжилтийн орлого /ТӨҮГ/		1,138,279,873.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	504,574,136.75	0.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	501,346,136.75	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	501,346,136.75	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,228,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,228,000.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	503,399,636.75	1,011,127,762.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	503,399,636.75	1,011,127,762.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	500,171,636.75	1,010,127,762.22

Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	303,382,185.00	487,789,083.00
210101	Үндсэн цалин	170,286,340.00	393,051,863.00
210102	Нэмэгдэл	58,061,894.00	29,402,620.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55,942,320.00	65,334,600.00
210104	Урамшуулал	19,091,631.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,150,600.00	59,859,642.00
210201	Тэтгэврийн даатгал	27,982,400.00	40,796,852.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,292,100.00	4,743,360.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,633,600.00	2,776,281.00
210204	Ажилгүйдлийн даатгал	658,400.00	1,965,075.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,584,100.00	9,578,074.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,368,266.73	293,492,751.00
210301	Гэрэл, цахилгаан	40,368,266.73	277,392,251.00
210303	Цэвэр, бохир ус	9,000,000.00	16,100,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,724,945.02	31,529,509.00
210401	Бичиг хэрэг	2,492,550.00	6,403,405.00
210402	Тээвэр, шатахуун	11,680,000.00	10,005,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,425,905.02	4,214,694.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,630,000.00	1,045,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	496,490.00	9,860,610.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,570,340.00	57,663,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,540,000.00	
210604	Урсгал засвар	17,030,340.00	57,663,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,975,300.00	54,014,327.22
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,871,800.00	50,729,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	143,100.00	235,232.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,800.00	452,704.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	648,800.00	2,160,600.00
210807	Газрын төлбөр	208,800.00	208,800.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		172,191.22
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	25,779,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		24,579,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,228,000.00	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,228,000.00	0.00

Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,228,000.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,174,500.00</u>	<u>127,152,110.88</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,174,500.00	30,530,930.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,174,500.00	30,530,930.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,174,500.00	30,530,930.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	1,174,500.00	30,530,930.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-1,174,500.00</u>	<u>-30,530,930.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	96,621,180.88
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	96,621,180.88

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	22,238,296,000.00		50,400,325,897.69		72,638,621,897.69
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	22,238,296,000.00	0.00	50,400,325,897.69	0.00	72,638,621,897.69
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	22,238,296,000.00	0.00	50,400,325,897.69	0.00	72,638,621,897.69
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	22,238,296,000.00	0.00	50,400,325,897.69	0.00	72,638,621,897.69
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	22,238,296,000.00	0.00	50,400,325,897.69	0.00	72,638,621,897.69
D08	Тайлант үеийн үр дүн			957,319,517.48		957,319,517.48
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	22,238,296,000.00	0.00	51,357,645,415.17	0.00	73,595,941,415.17

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	Өмнөх оны мөн үе	2025 он			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	дүн	хувь
	2	4	5	6	7	8
1	Төрөөс олгох үйл ажиллагааны дэмжлэг	501,346,136.0	800,000,000.0	800,000,000.0	0.0	100.0%
2	Бусад орлого	3,228,000.0	20,000,000.0	55,440,276.0	-35,440,276.0	36.1%

Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	Үнэ төлбөргүй авсан хөрөнгийн орлого	8,679,010,384.0		1,108,554,734.5	-	
4	Цахилгааны төлбөрийн орлого			282,839,597.1	-282,839,597.1	
5	Нийт үйл ажиллагааны орлого	504,574,136.0	820,000,000.0	2,246,834,607.6	-	36.5%
6	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	303,382,185.0	500,500,000.0	487,789,083.0	12,710,917.0	97.5%
7	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,150,600.0	59,860,000.0	59,859,642.0	358.0	100.0%
8	Гэрэл, цахилгаан	40,368,300.0	115,980,000.0	277,392,251.0	-161,412,251.0	41.8%
9	Цэвэр, бохир ус	9,000,000.0	18,000,000.0	16,100,500.0	1,899,500.0	89.4%
10	Бичиг хэрэг	2,492,550.0	6,500,000.0	6,403,405.0	96,595.0	98.5%
11	Тээвэр, шатахуун	11,680,000.0	11,520,000.0	10,005,800.0	1,514,200.0	86.9%
12	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,425,905.0	4,253,000.0	4,214,694.0	38,306.0	99.1%
13	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,630,000.0	1,050,000.0	1,045,000.0	5,000.0	99.5%
14	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	496,490.0	10,000,000.0	9,860,610.0	139,390.0	98.6%
15	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,540,000.0				
16	Тавилга		31,000,000.0	30,530,930.0	469,070.0	98.5%
17	Урсгал засвар	18,240,840.0	60,537,000.0	47,929,000.0	12,608,000.0	79.2%
18	Дотоод албан томилолт	500,000.0				
19	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,871,800.0	56,500,000.0	55,411,163.0	1,088,837.0	98.1%
20	Даатгалын үйлчилгээ	143,100.0	250,000.0	235,300.0	14,700.0	94.1%
21	Тээврийн хэрэгслийн татвар	69,800.0	500,000.0	402,700.0	97,300.0	80.5%
22	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.0	140,000.0	55,000.0	85,000.0	39.3%
23	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	648,800.0	2,500,000.0	2,160,600.0	339,400.0	86.4%
24	Газрын төлбөр	208,800.0	210,000.0	208,800.0	1,200.0	99.4%
25	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж			200,900.0	-200,900.0	
26	Бараа үйлчилгээний бусад зардал		16,000,000.0	11,199,600.0	4,800,400.0	70.0%
27	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх		1,200,000.0	1,200,000.0	0.0	100.0%
28	Элэгдэл	57,216,891.5		267,310,112.1	-267,310,112.1	
29	Нийт үйл ажиллагааны зардал	558,617,149.0		1,289,515,090.1	-	
30	Үйл ажиллагааны алдагдал	8,624,967,371.0		957,319,517.5	-957,319,517.5	
31	Нийт орлого	9,183,584,520.7		2,246,834,607.6	2,246,834,607.6	
32	Нийт зардал	558,617,149.7		1,289,515,090.1	1,289,515,090.1	
33	Татвар төлөхийн өмнөх алдагдал			957,319,517.5	-957,319,517.5	
34	Авлага	9,279,119.2		0.0	0.0	
35	Нийт өр төлбөр			890,351.0	-890,351.0	
36	Орон тоо	14.0	18.0	14.0	4.0	77.8%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгэм эдийн засаг, байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөөлөлгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэ дэвшилтэд болон өндөр технологи дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулах бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар төлөвлөгдсөн газрыг паркийн бүс болгон хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах чиг үүргийн хүрээнд:

- Барилгын материалын салбарт шинжлэх ухааны ололт, дэвшилтэт техник технологийг дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулах;
- Олон улсын стандартад нийцсэн импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих;
- Барилгын материалын салбарын эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;
- Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих;
- Барилгын материалын салбарын жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлэх, ажлын байр бий болгох;

3.2 Гадаад, дотоод орчин

Тайлант онд Налайхын үйлдвэр технологийн парк ХК-ийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай;
- Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 албан даалгавар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай”;

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

НЗДТГ-аас дотоод аудитыг хэрэгжүүлдэг ба тайлант онд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Налайхын үйлдвэр технологийн парк ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Налайхын үйлдвэр технологийн парк ХК-ийн даргын 2016 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн А/02 тоот тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГО, ТОЛИЛУУЛГАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Налайхын үйлдвэр технологийн парк ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 958,123.9 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	0.0	96,621.2	96,621.2
Авлага	9,279.1	-	-
Бараа материал	20,948.1	20,216.3	(731.7)
Үндсэн хөрөнгө	72,608,480.7	73,479,994.2	871,513.5
Нийт хөрөнгө	72,638,707.9	73,596,831.8	958,123.9
Өр төлбөр	86.0	890.4	804.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	72,638,621.9	73,595,941.4	957,319.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	72,638,707.9	73,596,831.8	958,123.9

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данс байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө 96,621.2 мянган төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй байна.

Он дамжсан хариуцагч нь тодорхойгүй 9,279.1 мянган төгрөгийн найдваргүй авлагыг ТУЗ-ын 2025 оны 8 дугаар тогтоолоор хаасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 20,216.3 мянган төгрөг болж 731.7 мянган төгрөгөөр буурсан нь 60,650.4 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 61,382.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 73,479,994.2 мянган төгрөг болж 871,513.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь НЗДТГ-ын 2025 оны А/361 дүгээр захирамж, тус байгууллагын захирлын 2025 оны А/01, А/11 дүгээр тушаалаар 1,014,348.7 мянган төгрөгийн үерийн байгууламж, 64,000.0 мянган төгрөгийн авто машиныг үнэ төлбөргүй, 33,314.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг бусад байгууллагаас хандиваар, 30,530.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, НӨХГ-ын 2025 оны 1/2216, А/641 дүгээр тушаалаар 27,758.7 мянган төгрөгийн хөрөнгө акталж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 165,130.5 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж, тайлант оны элэгдлийн зардлыг тооцож бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд тооцоо нийлсэн актаар баталгаажсан 890.4 мянган төгрөг байгаа нь татварын өглөг үүсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 958123.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Зорилтод түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Налайхын үйлдвэр технологийн парк ХК нь санхүүгийн төлөвлөгөө, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Налайхын үйлдвэр технологийн парк ХК нь ТУЗ-ын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 5 дугаар тогтоол оор эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин баталж тайлант оны нийт орлогыг 820,000.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 897,500.0 мянган төгрөгөөр, 77,500.0 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 2,246,834.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,289,515.1 мянган төгрөгийн зардал гарган, татварын дараах 957,319.5 мянган төгрөгийн ашигтай тайлагнасан байна. Орлого нэмэгдэж, ашигтай ажилласан нь гишүүнчлэлийн эрхийн төлбөр, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг орлогод бүртгэсэнтэй холбоотой байна.

Зорилт 1. Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго: 3.3.1. Багануур, Багахангай, Налайх, эмээлт дэх үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дуусгах ажлын зардалд 6,500.0 мянган төгрөг;

Зорилт 2. Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго: 3.3.2. Багануур, Налайх, Багахангай дүүрэгт хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийг дагалдах бусад үйлдвэрийн хамт байгуулах хувийн хэвшлийг дэмжих ажлын зардалд 74,500.0 мянган төгрөг;

Зорилт 3. Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээний бусад ажлын зардалд 161,394.2 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Налайхын үйлдвэр технологийн парк ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн нягтлан бодох бүртгэл болон хууль тогтоомжтой холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын албаны аудитор Г.Тэмүүжин гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Отгонбаяр, санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Налайхын үйлдвэр технологийн парк ХК нь 2025 оны санхүүгийн тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2025 оны санхүү байдлын тайлан, суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны нийт хөрөнгийн 73,596,831.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,103,952.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласнаар цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 12,710.9 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 704,714.1 мянган төгрөгийн 42 мэдээллийг хуулийн дагуу ил тод мэдээлэхээс хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт тус тус нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитын төлөвлөгөө хөтөлбөрт хамруулаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 20,580.6 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	20,580.6	1	20,580.6	100.0
Нийт дүн	1	20,580.6	1	20,580.6	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 38,400.0 мянган төгрөгийн 1 алдаа² илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 38,400.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд дансны ангилал буруу бүртгэсэн байна .

Энэ нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-т "Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх" болон санхүүгийн тайлагналын "тохиолдсон байх", "толилуулга" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байсныг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 82,175.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 82,175.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

5.2 Албан шаардлага

5.2.2 Худалдан авах ажиллагаанд мөрдөх босго үнийг баримталж ажиллаагүй 82,175.2 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.12-т "Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно", 34 дүгээр зүйлийн 34.1-т "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно", Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртийн дээд хязгаар тогтоох тухай 02 дугаар тогтоолтой тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Босго үнийн шаардлагыг мөрдөж ажиллаагүй шууд худалдан авалт хийсэн зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Дүн		Дүн		Дүн		Дүн		Залруулсан		Залруу лаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг үр дүнгийн тайланд дансны зүйл анги буруу тусган илэрхийлсэн байна.	1	38,400.0	-	-	1	38,400.0	-	-	1	38,400.0	-	-	-	-
Дүн	1	38,400.0	-	-	1	38,400.0	-	-	1	38,400.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Дүн		Дүн		Дүн		Дүн		Дүн		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсөвт өртгийг хувааж тендер зарлаагүй байгууллагын хөгжлийн төлөвлөгөө, тавилга угсралт, засварын ажлыг шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна	1	82,175.2	-	-	1	82,175.2	-	-	-	-	-	-
Дүн	1	82,175.2	-	-	1	82,175.2	-	-	-	-	-	-



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 328/АОРЭ/194

Улаанбаатар хот

НТАГ-2026/159/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын хөгжлийн төлөвлөгөө, тавилга угсралт, засварын ажлын 82,175,200.00 (наян хоёр сая нэг зуун далан таван мянга хоёр зуу) төгрөгийн худалдан авалтад худалдан авах ажиллагааны холбогдох хууль, журмыг мөрдөөгүй, төсөвт өртгийг хувааж шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.12-д "Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно", 34 дүгээр зүйлийн 34.1-д "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний төндөр шалгааруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолтой тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдах этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг төслэн зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол", заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

- Худалдан авах ажиллагааны хууль, журам мөрдөөгүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налайхын үйлдвэр, технологийн парк ХК-ийн дарга Ч.Раднаабазар, нягтлан бодогч Г.Ганцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Д.ОТГОНБАЯР
Г.ТЭМҮҮЖИН

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

142090696